



## АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАНГИЙН  
ХУРААНГУЙ ТАЙЛАН

### 1. Аудитын код: ДУА-2026/02-10/СТА-НА-НТГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Аудитор: Б.Сарангуа Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Doljinsurend@audit.gov.mn">Doljinsurend@audit.gov.mn</a> <a href="mailto:Saranguab@audit.gov.mn">Saranguab@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# “ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

## Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	2026/02-10/СТА-НА-НТГ	Аудитын хамрагдах хугацаа:	2025 он
Аудитын нэр:	“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын 1-р нэгж Аудитор Д.Должинсүрэн, Б.Сарангуа

### АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө
Аудитын зорилт:	<ul style="list-style-type: none"><li>Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;</li><li>Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, хууль, журмын дагуу зарцуулсан эсэх;</li><li>Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд хүрсэн эсэх.</li></ul>
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	<p>АДБОУС</p> <ul style="list-style-type: none"><li>Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020</li><li>Монгол Улсын Үндсэн хууль;</li><li>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;</li><li>Төсвийн тухай хууль;</li><li>Төрийн аудитын тухай хууль;</li><li>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;</li><li>Татварын багц хуулиуд;</li><li>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;</li><li>Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.</li></ul>
Аудитын хамарсан хүрээ:	Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 15 сумын төсвийн гүйцэтгэлийн тайлан, татварын мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, аймгийн болон сумдын орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан
Аудитын арга зүй:	АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүй

## Хоёр. Аудитын үр дүн

### А. Татварын орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй төлөвлөснөөс орон нутгаас бүрдүүлэх орлого 3,217.0 сая төгрөгөөр даван биелүүлсэн ч 6 нэр төрлийн татварын орлого тасарсан байна.



Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль болон аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн нийт орлогыг 119,577.2 сая төгрөгөөр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 Төсвийн орлогын төлөвлөгөөний задаргаа

/сая.төг/

№	Орлогын эх үүсвэр	2024 оны төлөвлөгөө			2025 оны төлөвлөгөө			Нэмэгдсэн /хасагдсан/
		Аймаг	Сум	Нийт	Аймаг	Сум	Нийт	
	А	1	2	3=1+2	4	5	6=4+5	7=6-3
1	Орон нутгийн хөгжлийн сан	15,880.4		15,880.4	13,039.8		13,039.8	(2,840.6)
2	Санхүүгийн дэмжлэг	18,195.6		18,195.6			0.0	(18,195.6)
3	Татварын болон татварын бус орлого	24,014.0	16,941.7	40,955.7	33,442.4	22,856.6	56,299.0	15,343.3
4	ОНЕО үлдэгдлээс	5,565.5	2,484.1	8,049.6	29,459.5	4,494.5	33,953.9	25,904.3
5	Төвлөрүүлэх орлого	1,257.3	2,307.6	3,564.9	2,453.3	1,888.6	4,341.9	777.0
6	Урьд оны үлдэгдэл	1,890.8	4,647.0	6,537.8			11,942.5	5,404.7
	Дүн	66,803.6	26,380.4	93,184.0	78,395.0	29,239.7	119,577.2	26,393.2

Өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд (ОНХС) олгох орлогын шилжүүлгийг 2,840.6 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 18,195.6 сая төгрөгөөр тус тус бууруулж, орон нутгийн төсвийн өөрийн орлогыг 47,429.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт дүнгээр 26,393.2 сая төгрөгөөр өсгөж төлөвлөсөн байна.

Тодруулбал, Сангийн яамнаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 14,580.0 сая төгрөгөөр төвлөрүүлэх боломжтой гэж хянасан байхад төсвийн тодотголоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал уг дүнг 1.7 дахин нэмэгдүүлж, 25,000.0 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлэх эрх үүсээгүй байхад Сангийн яамны хяналтаас 2.5 дахин өсгөж 4,700.0 сая төгрөгөөр, эх үүсвэр нь тодорхойгүй хүүгийн орлогыг 566.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Газрын төлбөрийн орлогын өсөлтийг аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй байгаа уул уурхайн 61 аж ахуйн нэгжийн 71 нэгж талбайн 107.1 мянган га газрыг гэрчилгээжүүлэн, 3,426.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолсон байна. Гэвч аж ахуйн нэгжүүд гэрчилгээ авах, газрын төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй байхад уг орлогыг төлөвлөсөн нь бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй бодитой төлөвлөөгүй байна.

Энэ нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа бодит тооцоо, судалгаанд тулгуурлаагүй, нэмж баталснаар төсвийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж, төсвийн тэнцэл алдагдах, улмаар санхүүжилтийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа бодит гүйцэтгэл, эдийн засгийн нөхцөл байдал, татварын бааз, эх үүсвэрийн тодорхой байдлыг нарийвчлан тооцож, үндэслэлтэй төлөвлөж батлах нь зүйтэй байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн орлого төлөлттэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр боллоо.



Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар /шинэчлэн найруулсан/ Дундговь аймагт 13,039.8 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 265.1 сая төгрөгөөр дутуу олгож, орон нутгийн орлогоос улсад төвлөрүүлэх шилжүүлэг 1,278.7 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 265.1 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого улсын төсөвт дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар суурь орлогыг 106,537.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр нийт 110,136.5 сая төгрөгийг төвлөрүүлэн 3.4 хувиар давуулсан байна.

*Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/сая.төг/*

№	Орлогын эх үүсвэр	2025 оны төлөвлөгөө			2025 оны гүйцэтгэл			Зөрүү
		Аймаг	Сум	Нийт	Аймаг	Сум	Нийт	
А		1	2	3=1+2	4	5	6=4+5	7=6-3
1	Татварын болон татварын бус орлого	33,442.4	22,856.6	56,299.0	36,690.9	22,825.1	59,516.0	3,217.0
2	ОНЕО үлдэгдлээс	29,459.5	4,494.5	33,953.9	30,262.3	5,096.2	35,358.5	1,404.6
3	Төвлөрүүлэх орлого	2,453.3	1,888.6	4,341.9	2,421.2	1,744.6	4,165.8	(176.1)
4	Урьд оны үлдэгдэл	2,401.3	9,541.2	11,942.5	2,401.3	8,694.9	11,096.2	(846.3)
<b>Дүн</b>		<b>67,756.4</b>	<b>38,780.9</b>	<b>106,537.4</b>	<b>71,775.7</b>	<b>38,360.8</b>	<b>110,136.5</b>	<b>3,599.2</b>

Татварын болон татварын бус орлого төлөвлөгөөнөөс 3,217.0 сая, орон нутгийн ерөнхий орлого 1,404.6 сая төгрөгөөр тус тус давж, урьд оны үлдэгдэл 846.3 сая, төвлөрүүлэх орлого 176.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт 3,217.0 сая төгрөгөөр давж биелснээс материаллаг хэмжээгээр давж биелсэн дараах 7 нэр төрлийн орлого байна.

Орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 10 сум болон аймгийн төв нийтдээ 5,129.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол Баянжаргалан, Өлзийт, Эрдэнэдалай, Сайнцагаан сумдын орлого 1,912.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энд тухайн сумдын газрын төлбөрийн орлого тасарсан нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 56,299.0 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 59,516.0 сая төгрөгийг төвлөрүүлж, тодотгосон орлогоос 3,217.0 сая төгрөгөөр давсан байна. Энэ нь тайланд онд нэг удаагийн шинжтэй орон нутгийн орлогын зарим нэр төрлийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Аудитаар нийт 6 нэр төрлийн орлогын тасалдлын шалтгаан, нөхцөл байдлыг судалсан. Орлогын төлөвлөгөөг анх батлахдаа бодит тооцоо, судалгаанд тулгуурлаагүйгээс хүүгийн орлого болон газрын төлбөрийн орлого тасалдах үндсэн шалтгаан болсон байна. Харин бусад 4 төрлийн орлогыг холбогдох албан хаагч, татварын байцаагч нарын хяналт, гүйцэтгэлийг сайжруулан, хариуцлагыг нэмэгдүүлснээр бүрэн төвлөрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Иймд орлого төвлөрүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч, татварын байцаагч нарын хариуцлага, гүйцэтгэлийн хяналтыг чангатгаж, үр дүнд суурилсан үнэлгээг хэрэгжүүлэн, орлогын биелэлтэд тогтмол хяналт тавьж, тасалдах эрсдэлийг эрт илрүүлэн, тухай бүр арга хэмжээ авч хэвших, мөн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах замаар орлогын баазыг өргөжүүлэх шаардлагатай байна.

Татварын орлогын биелэлтэд тогтмол хяналт тавьж, тасалдах эрсдэлийг тооцоолон, чиг үүрэг бүхий байгууллага албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулж, тухай бүр арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр боллоо.

Аудитаар нийт 1,853.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 11.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1,797.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэн, орлого бүрдүүлэлттэй холбоотой 40.3 сая төгрөгийн 1 зөвлөмж тус тус төсөв захирагч нарт хүргүүлсэн байна.

**Б. Төсвийн нийт зардлыг төлөвлөж, зарцуулахдаа сангийн яамнаас өгсөн чиглэлийг тусгасан ч төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.**



15 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсөвт тодотгол хийгдэж, Дундговь аймгийн орон нутгийн 2025 оны төсөв нийт дүнгээр 11,888.4 сая төгрөгөөр бууруулан, 119,577.2 сая төгрөг болж батлагдсан байна.

*Хүснэгт №3 Төсвийн зардлын өмнөх он, анх батлагдсан, тодотгосон төлөвлөгөө, харьцуулалт /сая.төг/*

Э/З ангилал	Өмнөх он	Тайлант он		Зөрүү	
		2024 оны №11 тогтоол	2025 оны №53 тогтоол	Өмнөх оноос	Анхны батлагдсан
Урсгал зардал	45,594.6	63,029.7	58,609.5	13,014.9	(4,420.2)
Хөрөнгийн зардал	45,313.6	65,593.9	56,371.3	11,057.7	(9,222.7)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	2,275.9	2,841.8	4,596.4	2,320.5	1,754.6
<b>Нийт дүн</b>	<b>93,184.1</b>	<b>131,465.5</b>	<b>119,577.2</b>	<b>26,393.1</b>	<b>(11,888.3)</b>

Төсвийн зардал өмнөх оноос 26,393.1 сая төгрөгөөр нэмэгдэж, анх батлагдсан төсвөөс 11,888.3 сая төгрөгөөр бууруулсан байна. Урсгал зардлыг 4,420.4 сая, хөрөнгийн зардлыг 9,222.7 сая төгрөгөөр эдийн засаг хүндэрсэнтэй холбоотой, хасаж тодотгосон байна. Харин аймгийн цэвэрлэх

байгууламжтай холбоотой дамжуулан төлөх зээлийн төлбөрийг нэмж төлөх болсноор эргэж төлөгдөх цэвэр зээлийг 1,754.5 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

2025 онд төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор жилийн дундуур төсөвт тодотгол хийж, 11,888.3 сая төгрөгөөр төсвийг бууруулж тодотгосон байна.



Дундговь аймгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг 119,577.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 69.0 буюу 82,469.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 57.0 хувийг урсгал зардал, 41.7 хувийг хөрөнгийн зардал, 1.3 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Хүснэгт №4 Төсвийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл

/сая.төг/

Үзүүлэлт	Нэгтгэл		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Урсгал зардал	58,609.5	47,005.4	11,604.1	57.0
Хөрөнгийн зардал	56,371.3	34,428.9	21,942.4	41.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	4,596.4	1,035.4	3,561.0	1.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	119,577.2	82,469.7	37,107.5	69.0

2025 оны сүүлээр төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилах, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний эрхийг түр хаасан. Үүний улмаас тайлант онд 2,896.4 сая төгрөгийн өглөг үүссэн бөгөөд уг өглөгийг бүрэн төлсөн гэж үзвэл гүйцэтгэл 2.4 хувиар нэмэгдэж, бодит төсвийн гүйцэтгэл 71.4 хувьтай байна.

Төсөвт байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар урсгал зардалтай холбоотой нийт 677.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь урсгал зардлын гүйцэтгэлийн 1.4 хувийг эзэлж байна.

### УРСГАЛ ЗАРДАЛ

Урсгал зардалтай холбоотой нийт зөрчлийн дийлэнх буюу 49.9 хувийг төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил эзэлж байгаа бөгөөд уг зөрчилд 18 албан шаардлагыг холбогдох төсөв захирагч нарт хүргүүлсэн байна.

Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг материаллаг дүнгээр авч үзвэл:

- Нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон хандивыг ОНХС-д төвлөрүүлээгүй, Засаг даргын Тамгын газрын дансаар дамжуулан зарцуулсан 200.0 сая төгрөг,
- Техник хяналтын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 105.8 сая төгрөгийн зөрчил байна.

Зөрчлүүдэд хийсэн дүн шинжилгээгээр төсөвт байгууллагуудын урсгал зардлын зарцуулалтад дотоод хяналт хангалтгүй, төсвийн сахилга бат алдагдсан нь зөрчлийн тоо, дүн өндөр гарахад нөлөөлсөн байна. Ялангуяа төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил зонхилж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар ашиглах эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Төсвийн тухай хуулийн 69.1<sup>1</sup>-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн төсөвт байгууллагуудыг холбогдох арга зүйгээр ханган ажиллуулахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд даалгах шаардлагатай байна.



Үндэсний аудитын газрын чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд золбин нохой, муурын устгалын талаарх судалгааг 15 сумаас авч нэгтгэн дүгнэв. Судалгааны дүнгээр Адаацаг, Сайхан-Овоо, Өлзийт сумд 2025 онд золбин нохой, муур устгах арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Бусад 12 сумын хэмжээнд нийт 2,636 эзэнгүй нохой, муурыг устгаж, үүнд 71.6 сая төгрөгийн зардал зарцуулсан байна.

Дүгнэхэд нохой, муур устгалын нэгжийн зардал сум бүрд харилцан адилгүй байгаа нь нэгдсэн тариф, зохицуулалт байхгүй байгаатай холбоотой байна. Энэ нь зардлыг өсгөж, зардлыг бодит гүйцэтгэлээс өндөр тогтоон, төсвийг үр ашиггүй зарцуулах үр дагавартай. Мөн санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус, янз бүрийн зардлаас зарцуулж байгаа нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтын нэгдмэл байдлыг алдагдуулж байна.

<sup>1</sup>Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

### **Сайн туршилага**

Дэлгэрхангай сум нь золбин нохой, муур устгах ажлыг орон нутгийн төсвийн санхүүжилтэд дангаар тулгуурлахгүйгээр иргэдээс хураамж төвлөрүүлэх хэлбэрээр зохион байгуулсан нь үр ашигтай сайн туршилага болж байна.

Муур, нохой устгах зардлыг иргэдээс гаргаснаар тэжээвэр амьтан эзэмшигчдийн хариуцлагыг нэмэгдүүлж, тэжээвэр муур, нохойдоо заслага хийлгэн, үржлийг хааснаар эзэнгүй муур нохойны тоо буурч, нийтийн эрх ашгийг хамгаалах ач холбогдлыг бий болгох үр дагавартай байна.

Ингэснээр төсвийн ачаалал буурч, иргэдийн хяналт, оролцоо сайжран, үйл ажиллагааны үр дүнд, золбин нохой муур цөөрөх боломжтой байна.

### **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**

2025 оны байдлаар Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгийн зардлын гүйцэтгэл 61.1 хувьтай буюу 21,942.4 сая төгрөгийн зардал дутуу зарцуулсан байна.

Хөрөнгийн зардалд дараах зардлууд багтсан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС), Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2025 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөг 26,156.5 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 15,511.0 сая төгрөг буюу 59.3 хувь нь зарцуулагдсан байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалт (ОНХО), Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 32,678.2 сая төгрөгийн өртөгтэй 72 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг аймгийн ИТХ-ын тогтоолоор тодотгол хийж, нийт 29,114.7 сая төгрөгийн 67 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж, анхны төлөвлөгөөнөөс 5 ТАХ бууруулж баталсан байна.

ОНХС-ийн нийт гүйцэтгэлд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон холбогдох орлогыг дутуу төвлөрүүлсэн тул орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Дундговь аймагт олгох орлогын шилжүүлгээс 261.1 сая төгрөгөөр дутуу орж ирсэн.
2. Зарим сумдын Малын тоо толгойн албан татварын орлого жилийн сүүлээр төвлөрч, уг орлогоор санхүүжих ТАХ-г хугацаандаа хэрэгжиж чадаагүй.
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын (*батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах*) гэж зааснаар хугацаандаа худалдан авах ажиллагааг зохион байгуулж амжаагүй тул ТАХ-г хэрэгжүүлэх боломжгүй болсон байна

Иймд Малын тоо толгойн албан татварын орлогыг хуулийн дагуу хагас, бүтэн жилээр төвлөрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулахад анхаарч, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд бүрэн зохион байгуулах төлөвлөгөөг жилийн эхэнд нарийвчлан баталж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

### **ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ**

Эргэн төлөгдөх зээлийн 2025 оны төлөвлөгөөг 4,641.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл 1,035.0 сая төгрөгт хүрч, 22.3 хувийн хэрэгжилттэй байна. Тайлант онд “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээл олголт өмнөх оноос 945.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээл нь сумдын хөгжлийг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл бөгөөд өмнөх оноос зээл олголтын хэмжээ өссөн нь цаашид энэ өсөлтийг хадгалж чадвал үр өгөөжөө нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Гүйцэтгэл болон санхүүгийн аудитаар илэрсэн Хоршоо хөгжүүлэх сангийн нийт 124.5 сая төгрөгийн төлбөрийн актыг үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүд тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулж, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

**В. 7. Хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг хэмжих 8 шалгуур үзүүлэлт тодорхой бүс, сүүр болон зорилтот түвшинг оновчтой тогтоогоогүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.**

Аудитаар шалгуур үзүүлэлтийн оновчтой байдлыг 9 үзүүлэлтээр, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийн уялдааг 8 үзүүлэлтээр үнэлж, нягтлах хяналтын хуудсыг УАГ-аас боловсруулсан

ирүүлсний дагуу шалгасан. Аудитаар зарим үзүүлэлт тодорхой бус, мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга тодорхойгүй, харин мэдээлэл цуглуулах зардлыг 100 хувь тусгасан, бусад үзүүлэлтийн хангалт 81.3–96.9 хувьтай, нийт 288 оноо авахаас 204 оноо авч, 70.8 хувьтай үнэлэгдлээ.

Иймд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа МАЯГТ ТМ-01а-ийн зааврын дагуу SMART (тодорхой, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, бодитой, хугацаатай) шаардлагад нийцүүлэн боловсруулж хэвших шаардлагатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тус зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар аймгийн Засаг Даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн 01/1592 дугаар албан бичгээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн орлогын нэр төрлийг бодит тооцоо, судалгаанд үндэслэн эх үүсвэрийг тодорхойлон батлах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй газрын орлого нь их хэмжээгээр тасарсан тул аймгийн ТЕЗ-д хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

### Дүгнэлт

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:**

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг зогсоож, уул уурхайн ААНБ-ийн татварын ОАТ-ын орлоготой холбоотой орон нутгийн төсвөөс санхүүжих орлогыг нэмсэн байна.
2. Аж ахуйн нэгжүүд гэрчилгээ авах, газрын төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй байхад уг орлогыг төлөвлөсөн нь бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй төлөвлөж, баталснаас орлогын төлөвлөгөө 3,052.6 сая төгрөгөөр тасарсан байна.
3. 2025 оны зөрчлийг өмнөх онтой харьцуулбал анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зөрчил нь 1.8 сая, зориулалт бусаар зарцуулсан зөрчил нь 228.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь дотоод хяналт сул байгааг харуулж байна.
4. Нохой, муур устгалын нэгжийн зардал сум бүрд харилцан адилгүй байгаа нь нэгдсэн тариф, зардлын зохицуулалт байхгүй байгаатай холбоотой байна.
5. ОНХС-ийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй зөрчил 1,760.6 сая төгрөгт хүрч нэмэгдсэн бөгөөд зарим сумдад худалдан авах ажиллагааг хугацаанд нь хэрэгжүүлж чадаагүй нь орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын гүйцэтгэл 59.3 хувьд хүрэхэд голлох нөлөө үзүүлсэн байна.
6. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний 38 үзүүлэлтүүдийн оновчтой байдал, төлөвлөлтийн уялдааг шалгахад зарим үзүүлэлт хангалтгүй байна.
7. Хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт тодорхой бус, суурь болон зорилтот түвшинг оновчтой тогтоогоогүйгээс зарим үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна.
8. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажилласан ч, зарим хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй байна.

## **Зөвлөмж**

**Аудитын дүн дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:**

**Аймгийн Засаг даргад:**

1. Орлогын төлөвлөгөө тасарсан 6 нэр төрлийн татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах;
2. Санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрыг төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа байгууллагуудыг арга зүйн удирдлага, зөвлөмжөөр ханган ажиллуулах;
3. Нохой, муур устгалын нэгжийн үнийг бодит өртөгт үндэслэн аймгийн хэмжээнд тариф тогтоож, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгон, тухайн зардлыг төсөвт тусган, батлуулж, хяналт тавьж ажиллах;
4. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд бүрэн зохион байгуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах;
5. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүд тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулж, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх.
6. Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа МАЯГТ ТМ-01а-ийн зааврын дагуу SMART (тодорхой, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, бодитой, хугацаатай) шаардлагад нийцүүлэн боловсруулж хэвиших;
7. Хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилтийг хариуцагч байгууллагаас авахдаа хөтөлбөрийн суурь болон зорилтот түвшиний дагуу гаргуулан авч хяналт тавих;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг  
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39  
E-mail: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn) 